



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 4/513

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 181 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд 91 хяналтын постод ажиллаж байгаа 414 төрийн албан хаагчдын, хоолны зардалд Боловсрол, Шинжлэх ухааны Сайдын 2020 оны 1а/2788 албан бичгээр ирүүлсэн чиглэл, зөвшөөрлийн дагуу 121,054,400 (нэг зуун хорин нэгэн сая тавин дөрвөн мянга дөрвөн зуу) төгрөг зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулах 121,054,400 ( нэг зуун хорин нэгэн сая тавин дөрвөн мянга дөрвөн зуу) төгрөгийг Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын хүүхдийн хоолны зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д. Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А. ИШДОРЖ

011101145